



Долоо хоног тутмын хэвлэл
2015 оны 12 дугаар сарын 11
№46 /907/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

2061

**Монгол Улсын
Үндсэн хуулийн
цэцийн тогтоол**

2069

**Дунд хугацааны стратеги
батлах тухай**

**Монгол Улсын Их Хурлын
сонгуулийн тухай хуулийн
26 дугаар зүйлийн 26.6
дахь хэсэг Үндсэн хуулийн
холбогдох заалтыг зөрчсөн
эсэх маргааныг дахин хянаж,
эцэслэн шийдвэрлэсэн тухай**



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|------|---|------------|------|
| 543. | Дунд хугацааны стратеги батлах тухай | Дугаар 396 | 2061 |
| 544. | Тогтоолд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 425 | 2067 |
| 545. | Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 426 | 2068 |

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

| | | | |
|------|---|-----------|------|
| 546. | Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэсэн тухай | Дугаар 10 | 2069 |
|------|---|-----------|------|

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 10 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 396

Улаанбаатар
хот

Дунд хугацааны стратеги батлах тухай

Улсын Их Хурлын 2015 оны 62 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хавсралт ёсоор баталсугай.

2. Дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгасугай.

3. Дунд хугацааны стратегийн зорилт, арга хэмжээг өөрийн эрхлэх асуудлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Стратегийн зорилт, арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, жил



бүрийн төсөвт тусгаж, гадаадын зээл, тусламж болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах ажлыг зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Сангийн сайд Б.Болор нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЙД

Д.ЭРДЭНЭБАТ

Засгийн газрын 2015 оны 396 дугаар
тогтоолын хавсралт

**ТӨРӨӨС АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ
(2015-2020 ОН)**

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод “Монгол Улс экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан, хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн өсөлт, хөгжлийн стратегийг сонгож байна” гэж заасан бөгөөд улмаар “Хувийн хэвшилд түшиглэсэн, өндөр технологид суурилсан, экспортын баримжаатай, боловсруулах салбарын үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийг олон талтай болгож, ашигт малтмалаас харьцангуй бага шалтгаалдаг орон болно” гэсэн зорилгыг дэвшүүлсэн.

Өнөөгийн байдлаар манай улсын аж үйлдвэрийн салбарын бүтэц нь уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эдэд тулгуурласан, хялбар технологи дээр суурилсан өрөөсгөл бүтэцтэй байгаа бөгөөд экспортын бүтээгдэхүүний 97 хувийг технологийн багтаамжгүй болон нам технологит бүтээгдэхүүн эзэлж байна. Иймээс аж үйлдвэрийн салбарыг төр, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурласан, дэвшилтэт техник, технологи, инновацид суурилсан, өндөр бүтээмж, өрсөлдөх чадвар бүхий хөгжлийн тэргүүлэх салбар болгохын тулд Улсын Их Хурлын 2015 оны 62 дугаар тогтоолоор “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан.

Улсын Их Хурлын 2015 оны 62 дугаар тогтоолын 2 дугаар заалтын 1 дэх хэсэгт “бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги хөтөлбөрийг таван жилээр төлөвлөж, холбогдох төлөвлөгөө, төслийг боловсруулан баталж, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулах”-ыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан нь “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги” (цаашид “стратегий” гэх)-ийг боловсруулах үндэслэл болно.



Хоёр. Стратегийн хамрах хүрээ, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах зарчим

2.1. Хамрах хүрээ

Стратеги нь уул уурхайн олборлох, баяжуулах үйлдвэрлэлээс бусад аж үйлдвэрийн салбарын хүрээнд үйлчилнэ.

2.2. Хэрэгжүүлэх хугацаа

Стратегийг 2015-2020 онд хэрэгжүүлнэ (“Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх I үе шат)

2.3. Баримтлах зарчим

Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

2.3.1. тогтвортой хөгжлийн зарчимд нийцсэн, ногоон технологид суурилсан үйлдвэрлэлийг дэмжих;

2.3.2. экспортын чиг баримжаатай, импортыг орлох эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих;

2.3.3. дэвшилтэт техник, технологи, инновацид суурилсан өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих;

2.3.4. төр, шинжлэх ухаан, иргэний нийгэм, хувийн хэвшлийн түншлэлийн үр ашигтай хамтын ажиллагаанд тулгуурлах;

2.3.5. аж үйлдвэрийн салбарын мэдээллийн ил тод байдал, оролцогч талуудын шударга өрсөлдөөнийг дэмжих.

Гурав. Стратегийн зорилго, зорилт

3.1. Стратегийн зорилго

Стратегийн зорилго нь үндэсний үйлдвэрлэлийг хамгаалж, түүхий эдийг дотооддоо боловсруулж, дэвшилтэт техник, технологийг нутагшуулан экспортыг дэмжих, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд оршино.

3.2. Стратегийн зорилт

Зорилт 1. Үйлдвэрлэл, худалдааг дэмжсэн, үйлдвэрлэл, худалдаа эрхлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;

Зорилт 2. Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс, орон зайн горимыг тодорхойлж, үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоох, Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал боловсруулах, салбарын мэдээллийн тогтолцоог сайжруулах;

Зорилт 3. Бүс нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдийг тогтоон, үйлдвэрийг кластераар хөгжүүлэх стратегийг боловсруулан, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркийг эдийн засгийн тооцоо, үр өгөөжид үндэслэн дэд бүтцийн хамт цогцоор нь төлөвлөн хэрэгжүүлэх;



Зорилт 4. Дэвшилтэт техник, технологи, инновацид суурилсан боловсруулах, дахин боловсруулах үйлдвэрүүдийг санхүүгийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

Зорилт 5. Мэдлэгийн менежментийг хэрэгжүүлэх замаар бүтээлч аж үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж, шинэ чадавх, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох;

Зорилт 6. Үйлдвэрлэлийн хүний нөөцийн эрэлтэд суурилсан ажиллах хүч бэлтгэж, тогтвор суурьшилтай ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх.

Дөрөв. Стратегийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Үйлдвэрлэл, худалдааг дэмжсэн, үйлдвэрлэл, худалдаа эрхлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.1.1. үйлдвэрлэл, худалдааг дэмжсэн хууль, эрх зүйн актыг шинээр боловсруулан баталж мөрдүүлэх;

4.1.2. худалдааны эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, тарифын болон тарифын бус зохицуулалтыг олон улсын гэрээнд нийцүүлэн шинэчлэх;

4.1.3. татварын бодлого, санхүүгийн түрээс, зээлийн батлан даалт, хөрөнгийн барьцааны эрх зүйн орчныг сайжруулах.

4.2. Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс, орон зайн горимыг тодорхойлж, үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоох, Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал боловсруулах, салбарын мэдээллийн тогтолцоог сайжруулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.2.1. “Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс”-ийг тодорхойлж батлуулах;

4.2.2. “Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс”-тэй уялдуулан үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоох;

4.2.3. Аж үйлдвэрийн салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх.

4.3. Бүс нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдийг тогтоон, үйлдвэрийг кластераар хөгжүүлэх стратегийг боловсруулах, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл технологийн паркийг эдийн засгийн тооцоо, үр өгөөжид үндэслэн дэд бүтцийн хамт цогцоор нь төлөвлөн хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.3.1. “Үйлдвэрийг кластераар хөгжүүлэх стратеги”-ийг боловсруулж батлуулах;

4.3.2. төмөр, зэс, тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүн, кокс үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж, газрын тос боловсруулах, зэс хайлуулах, алт цэвэршүүлэх үйлдвэрүүдийг барьж байгуулах ажлыг эхлүүлэх;



4.3.3. нийтийн тээврийн хэрэгслийн үйлдвэр, металл хийцийн эд ангийн үйлдвэр, уул уурхай, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх;

4.3.4. хөнгөн үйлдвэрийг кластераар хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн бүтээгдэхүүний экспортод эзлэх хувь, хэмжээг нэмэгдүүлэх;

4.3.5. “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан батлан хэрэгжүүлэх;

4.3.6. хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн чанар, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулан, ногоон технологид суурилсан экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

4.3.7. аж үйлдвэрийн салбарын тээвэр, логистикийн сүлжээг хөгжүүлэх;

4.3.8. чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парк, шинжлэх ухаан технологийн парк, хүнд аж үйлдвэрийн цогцолборуудын инженерийн дэд бүтцийг цогцоор нь барих үйл ажиллагааг дэмжих;

4.3.9. үйлдвэрлэлийн технологи, дэд бүтцэд ногоон эрчим хүч ашиглах, хаягдал усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж, дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжих.

4.4. Дэвшилтэт техник, технологи, инновацид суурилсан боловсруулах, дахин боловсруулах үйлдвэрүүдийг санхүүгийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.4.1. инноваци, өндөр технологи, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний судалгаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих;

4.4.2. төр болон шинжлэх ухаан, боловсрол, бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжиж, экспортод чиглэсэн инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.

4.5. Мэдлэгийн менежментийг хэрэгжүүлэх замаар бүтээлч аж үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж шинэ чадавхи, бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.5.1. соёлын салбарын статистикийг нэвтрүүлэх, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

4.5.2. үндэсний түүх, соёлын онцлогтой шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож хөгжүүлэх.

4.6. Үйлдвэрлэлийн хүний нөөцийн эрэлтэд суурилсан ажиллах хүчин бэлтгэж, тогтвор суурьшилтай ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.6.1. инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх, чадавхжуулах тогтолцоог сайжруулах;

4.6.2. ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх.



Тав. Стратегийн хэрэгжилтийг зохион байгуулах

Стратегийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна.

Зургаа. Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт

6.1. Стратегийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

6.1.1. гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хувийн хөрөнгө оруулалт;

6.1.2. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

6.1.3. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгө;

6.1.4. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгө;

6.1.5. Инновацийг дэмжих сангийн хөрөнгө;

6.1.6. Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгө;

6.1.7. Засгийн газрын үнэт цаас;

6.1.8. концесс;

6.1.9. гадаадын зээл, тусламж;

6.1.10. бусад эх үүсвэр.

Долоо. Стратегийн үр дүн, шалгуур үзүүлэлт

7.1. Стратегийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

7.1.1. үйлдвэрлэл, худалдаа эрхлэх эрх зүйн таатай орчин бүрдэж, боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, хэмжээ өснө;

7.1.2. гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын таатай орчин бий болж, худалдааны эргэлт сайжирч, экспортын зах зээл өргөжин, стандарт, гарал үүсэл хангасан бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж, өрсөлдөх чадвар өснө;

7.1.3. “Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс” батлагдсанаар гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг тодорхой чиглэл, байршилд зохистой төвлөрүүлж, эрсдэлийг бууруулах нөхцөл бүрдэнэ;

7.1.4. “Аж үйлдвэрийн салбарын статистик мэдээлэл, газарзүй, гео мэдээллийн сан” бий болж, мэдээлэл нийтэд ил, тод нээлттэй болно;

7.1.5. Чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парк, шинжлэх ухаан технологийн парк, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк, хүнд аж үйлдвэрийн цогцолборуудын дэд бүтцийг байгуулж, логистикийн сүлжээ бий болсноор хүнд, хөнгөн үйлдвэрийн кластерууд хөгжин экспортын чиг баримжаатай, импортыг орлох эцсийн бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэх нөхцөл бүрдэнэ;



7.1.6. “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк”-ууд орон нутагт байгуулагдаж, олон улсын стандартын шаардлага хангасан, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэгч орон болох эхлэл тавигдана;

7.1.7. Өндөр технологи бий болгох, бойжуулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, инновацийн бүтээгдэхүүн зах зээлд гаргах цогц үйл ажиллагааг дэмжин ажилласнаар нэмүү өртөг шингэсэн өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэнэ;

7.1.8. Бүтээлч аж үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлснээр үндэсний түүх, соёлын онцлогтой шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болно;

7.1.9. Ажилчид тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдсэнээр өндөр мэргэжилтэй инженер, техникийн ажилчид эх орныхоо үйлдвэрүүдэд ажиллаж, бүтээмж нэмэгдэнэ.

Найм. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

8.1. Стратегийн хэрэгжилтийг зорилт, үйл ажиллагааны үр дүнгээр нь үнэлнэ.

8.2. Стратегийн хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг стратегийн зорилго, арга хэмжээ тус бүрээр аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.3. Стратегийн хэрэгжилтэд аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг дараа жилийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 2-ны өдөр

Дугаар 425

Улаанбаатар
хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2009 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 13 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1. Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг 1500 хүртэл хүн амтай суманд 12, 1501-3000 хүртэл хүн амтай суманд 14, 3001-5000 хүртэл хүн амтай суманд 15, 5001-10000 хүртэл хүн амтай суманд 17, 10001-20000 хүртэл хүн амтай суманд 20, 20001-ээс дээш хүн амтай суманд 22 байхаар тус тус тогтоосугай.”



2. Сумын Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгжийн орон тоог тухайн сумын газар зүйн байршил, хүн амын тоо, баг, тосгоны алслагдсан байдал, газар тариалан, мал аж ахуй эрхлэлтийн түвшинг харгалзан энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан орон тооны дээд хязгаарт багтаан тогтоож, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

САНГИЙН САЙД

Б.БОЛОР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 2-ны өдөр

Дугаар 426

Улаанбаатар
хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Санхүүгийн алба байгуулах тухай” Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 326 дугаар тогтоолд дор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмсүгэй:

“4. Аймгийн төвийн сум болон 8001-ээс дээш хүн амтай сумын Санхүүгийн албаны орон тооны дээд хязгаар 3 байхаар тогтоосугай.”

2. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа төсөвт байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн алба хариуцан гүйцэтгэж байгаатай холбогдуулан аймгийн төвийн сум болон 8001-ээс дээш хүн амтай сумаас бусад суманд үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн төсөвт байгууллагуудад нягтлан бодогч давхардуулан ажиллуулахгүй байхыг аймгийн Засаг дарга болон холбогдох төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Санхүүгийн алба байгуулах тухай” Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 326 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

САНГИЙН САЙД

Б.БОЛОР

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 11.30 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Амарсанаа даргалж, гишүүдэд Н.Жанцан, Т.Лхагваа /илтгэгч/, Ш.Цогтоо, Д.Сугар, Д.Наранчимэг, Д.Солонго, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд өргөдөл гаргагч, иргэн Ч.Өлзийсайхан, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт “Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна.” гэж заасны “...бусад төрийн албан хаагч...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэснийг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэв. Мөн “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 12 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 84 дүгээр тогтоолыг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны оршин суугч, иргэн Ч.Өлзийсайхан Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөл, гомдолдоо:

“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт “Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна.” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван



дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхах үл болно. Хүн бүр эрх зүйн тэгээд байна.” гэснийг зөрчиж байна.

Улсын Их Хурлын Тамгын газрын судалгаа шинжилгээний хэлтсээс 2014 оны 2 дугаар сарын 14-ний өдөр гаргасан лавлагаанаас харвал Монгол Улсад 162769 төрийн албан хаагчид байна. Эдгээрээс төрийн улс төрийн албан тушаалд 2798, төрийн захиргааны албан тушаалд 16179, төрийн тусгай албан хаагчид 28773, төрийн үйлчилгээний албан тушаалд 115019 хүн ажиллаж байна. Энэ хууль батлагдан гарахаас өмнө төрийн улс төрийн албан тушаал эсвэл төрийн захиргааны албан тушаалд ажиллаж байсан хүмүүс албан тушаалаа ашиглан, төрийн оролцоотой хийж бүтээсэн ажлыг өөрийн хийж бүтээсэн зүйл мэтээр өөрийгөө сурталчилж, сонгуулийн өмнө сурталчилгаа хийх болсонтой холбоотойгоор энэ байдлыг залруулах зорилготой хуулийн зохицуулалт хийсэн байдаг. Гэтэл энэхүү хууль батлагдсанаар төрийн оролцоотой бүтээн байгуулалтыг өөрийн хийсэн зүйл мэтээр сурталчлах ямар ч боломжгүй төрийн байгууллагад ажиллаж байдаг олон мянган иргэд Үндсэн хуульд заасан сонгогдох эрхээ хязгаарлуулсан билээ. ...

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн энэхүү заалт нь “эрхэлсэн ажил, байдал”-аараа, өөрөөр хэлбэл, яг адилхан төрлийн хөдөлмөр эрхэлж байгаа боловч төрөөс цалинг нь олгодог байгууллагад ажилладаг “байдлаараа” л ганцхан ялгагдаж байгаа хүмүүс өөр өөр эрх эдэлж, ялгаварлан гадуурхагдахад хүргэсэн байна. Энэ нь төрийн өмчит байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдыг хувийн өмчит байгууллагад ажиллаж байгаа ижил төрлийн хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсээс өөрөөр хандаж тэгш бус хандсан гэж үзэж байна. Сонгуулийн хуулийн энэхүү заалт нь төрийн улс төрийн албан тушаалтан, төрийн захиргааны албан тушаалтан, төрийн тусгай албан хаагчдад тавигдах шалгуурыг зохицуулах гэсэн зорилгоосоо гажиж “Тусгай харилцааг тухайлан зохицуулсан хэм хэмжээг бусад харилцаанд төсөөтэй хэрэглэж үл болно.” гэсэн Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг зөрчин батлагдсан байдаг.

Хэрвээ төрийн байгууллагад ажиллаж байгаа хүмүүсийн ажил төрөл, үйл ажиллагаа нь сонгуулийн үйл явцад мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээр хор уршигтай байдаг бол яг ийм төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшилд ажиллагсдад ч энэ шаардлага тавигдах ёстой билээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.11 дэх хэсэгт “Энэ хуулийн 26.6-д зааснаар төрийн албанаас чөлөөлөгдсөн иргэн төрийн албанд эргэж ороход Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан журмыг баримтална.” гэж заажээ. Тэгвэл Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар ул орон тоог нөхнө.”, 17.4 дэх хэсэгт “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог энэ хуулийн 17.1-д заасан албан хаагчдаас нөхөх боломжгүй бол төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн



иргэдээс уг албан тушаалд тавих онцлог, шаардлагыг харгалзан шалгаруулж авах тухай хүсэлтээ төрийн албаны төв байгууллагад тавина.” гэж заажээ.

Төрийн албаны тухай хуульд зааснаар Монгол Улсын иргэн хүн Үндсэн хуульд заасан сонгогдох эрхээ эдэлсний улмаас ажлаасаа халагдахаас өөр аргагүй болж байгаа бөгөөд хэрэв сонгуульд ялагдал хүлээсэн тохиолдолд ямар ч ажилгүй, цалин хөлсгүй ч болж мэдэхээр болж байна. ... Төрийн үйлчилгээний албан хаагчдыг ажлаасаа гарч тухайн оны нэгдүгээр сарын нэгний өдрөөс эхлэн ажилгүй ч байж болох нөхцөл байдал руу албадан оруулж байгаагаараа иргэн сонгуульд оролцоход нь “албадан нөлөөлж, саад учруулж байгаа хэрэг болно. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад заасан иргэний баталгаатай эдлэх ёстой эрх болох сонгох, сонгогдох тэгш эрхийг хөндсөн байна.

Улсын Их Хурлаар баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн заалт нь мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “... шударга ёс, ... үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна.

“Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсэн Үндсэн хуулийн заалтыг биелүүлж яг адилхан хөдөлмөр эрхэлж байгаа бусад хүмүүсээсээ ялгаатай байгаа 115019 иргэнийхээ эрхийг сэргээж, Үндсэн хуулиа чандлан сахиулсан шийдвэр гаргаж өгнө үү” гэжээ.

Хоёр. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн А.Бакей Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн хариу тайлбартаа:

“Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй талаар:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт төрийн албан хаагч нь улс төрийн сонгуульд оролцож өрсөлдөхөөр бол төрийн алба болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх шаардлагыг бий болгосон нь улс төрийн сонгуульд нэр дэвшигчид ижил тэнцүү нөхцөлд, шударгаар өрсөлдөх боломжийг бүрдүүлэх, төрийн алба улс төрөөс ангид байх зарчмыг хэрэгжүүлэх хууль ёсны зорилгод тулгуурласан. Нөгөө талаас төрийн алба мэргэшсэн, тасралтгүй, тогтвортой байх нөхцөлийг төр бүрдүүлэх ёстойг харгалзан үзсэн.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт заасан шаардлага нь агуулгаараа сонгогдох эрхийн хязгаарлалт биш юм. Төрийн албан хаагч нь улс төрийн сонгуульд нэрээ дэвшүүлэн оролцохоор бол Үндсэн хуулийн суурь зарчим, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн хууль ёсны зорилгыг ханган биелүүлэхтэй уялдан тухайн нэр дэвшигчид тавигдаж байгаа нэмэлт болзол, шаардлага юм.



Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчөөгүй талаар:

Төрийн албан хаагчид нь төрөөс цалинждаг гэсэн агуулгаараа ялгаварлан гадуурхагдаж, Үндсэн хуульд заасан сонгогдох эрхээ хязгаарлуулсан, хувийн болон төрийн өмчит байгууллагад ажиллаж байгаа ижил төрлийн хөдөлмөр эрхлэгчдэд сонгогдох эрхээ эдлэхэд тэгш бус хандсан нь Үндсэн хууль зөрчсөн гэж мэдээлэл гаргагч үзжээ.

Сонгуулийг бодитой, шударгаар явуулахад нэр дэвшигчид тавигдах хуулийн шаардлага, болзол нөхцөл бий. Түүнийг өмчийн аль хэлбэрт ажиллаж байгаагаас үл хамааран тухайн этгээд биелүүлсэн байх ёстой. Харин төрийн албан хаагчийн хувьд төрийн албанаас чөлөөлөгдсөн байх нэмэлт шаардлагыг тогтоосон. Төрийн албан хаагч сонгуульд оролцоход төрийн албаны нэр хүндийг буруугаар ашиглах, төсвийн хөрөнгийг зарцуулах, төрийн албан хаагчийн хувьд үзүүлсэн үйлчилгээ, бүтээсэн зүйлийг өөрийн нэрийн өмнөөс сурталчлах, таниулах байдлаар бусад нэр дэвшигчдээс илүү, давуутай байдлыг бий болгохоос урьдчилан сэргийлэх, хууль бус аливаа үйлдлээс бусад нэр дэвшигчийг хамгаалах, эрх зүйн ижил гарааны нөхцөл бүрдүүлэх, сонгогчийн сонгуульд саналаа өгөх, жинхэнэ хүсэл зоригоо бодитой илэрхийлэх боломжийг баталгаажуулахын ач холбогдлыг хууль тогтоогч тооцон үзсэн. Харин хувийн хэвшлээс нэр дэвшсэн этгээдэд энэ заалтыг халдаан хэрэглэх агуулга, ач холбогдол байхгүйн зэрэгцээ хувийн өмчит этгээдийн хөдөлмөрийн дотоод үйл ажиллагаанд төрөөс хутгалдан оролцох нь харин Үндсэн хуулийн үзэл санаанд нийцэхгүй байх болно.

Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтыг зөрчөөгүй талаар:

Хуулийн заалтаар иргэний тэр дундаа төрийн албан хаагчийн Улсын Их Хурлын сонгуульд сонгогдох эрхийг хязгаарласан шууд болон шууд бус ямарваа хориг, хязгаарыг бий болгоогүй. Төрийн жинхэнэ албанаас улс төрийн салбарт шилжин ажиллах сонголт нь хувь хүний Үндсэн хуулиар олгогдсон ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийнхээ дагуу хийж байгаа ухамсарт үйлдэл мөн бөгөөд түүнд нөлөөлөх, эсхүл түүнийг ямарваа хэлбэрээр хязгаарлан хуульчлах нь өөрөө Үндсэн хуулийн суурь зарчим, үнэт зүйлсээс ухарсан алхам болох билээ.

Харин сонгуульд оролцож ялагдсан төрийн албан хаагчийн хувьд түүнийг төрийн албанд буцаан авах нөхцөл, журмыг тогтоосон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байж болохыг тэмдэглэж байна.

Дээр дурдсаныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтыг тус тус зөрчөөгүй гэсэн тайлбарыг үүгээр Танд уламжилж байна.” гэжээ.

Гурав. Уг маргаанд холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн тайлбарт:

“Сонгуулийн ерөнхий хороо нь Монгол Улсын Үндсэн хууль, Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд заасны дагуу хууль дээдлэх зарчмыг баримтлан ажиллаж байна. Сонгуулийн ерөнхий хороо нь Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын болон Монгол Улсын

Ерөнхийлөгчийн сонгууль, ард нийтийн санал асуулгыг зохион байгуулж явуулах бүрэн эрхтэй төрийн байгууллага бөгөөд сонгуулийн тухай хууль, хуулийн заалттай холбогдуулан тайлбар гаргах эрх тус Хороонд хуулиар олгодоогүй байна.” гэсэн байна.

Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дунд суудлын хуралдаанаар энэхүү маргааныг хэлэлцэж 12 дугаар дүгнэлт гаргасан байна.

Уг дүгнэлтийн үндэслэх хэсэгт:

“1. Төрийн жинхэнэ буюу мэргэшсэн алба хаагчдыг ажил, мэргэжлийн онцлог, хэрэгжүүлэх чиг үүргийг харгалзан улс төрийн үйл ажиллагаанаас ангид байлгах, төвийг сахисан байр суурийг хадгалахад чиглэсэн тусгай шаардлага, шалгуурыг тэдэнд тавьж холбогдох хуулиар зохицуулах нь хууль тогтоогчийн бүрэн эрхийн асуудал юм. Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт энэ талаар тухайлан зохицуулсан байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэлэлцэн баталсан Байнгын хороо болон Чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбараас үзэхэд хууль тогтоогч төрийн эрх мэдэл бүхий албан тушаалтан өөрийн бүрэн эрх, албан тушаалаа сонгуулийн үйл ажиллагаанд ашиглан давуу байдал үүсгэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсгийн зохицуулалтыг тогтоосон байна.

Гэтэл эл зохицуулалтад төрийн үйлчилгээний албан хаагчдыг хамааруулан “бусад төрийн албан хаагч” хэмээн зааж хуульчилсан нь хууль тогтоогчийн анхны зорилгод нийцээгүй, Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших тохиолдолд хэт өргөн хүрээнд шаардлага тавьсан байна.

Дээрхээс үзэхэд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт “Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна.” гэж хуульчлан төрийн үйлчилгээний албан хаагчдыг төрийн жинхэнэ алба хаагчтай адилтган нэгэн адил шаардлага, шалгуурыг тавьж, улмаар тэдгээртэй эрх зүйн байдал болон гүйцэтгэж буй чиг үүргийн хувьд ижил ажил эрхэлж байгаа хувийн хэвшлийн ажилтантай харьцуулахад тэгш бус нөхцөл, хязгаарыг тогтоосон нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэснийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, ...үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэснийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.” гээд

**Уг дүгнэлтийн дүгнэлт гаргах хэсэгт:**

“1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт “Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна.” гэж заасны “...бусад төрийн албан хаагч...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэснийг зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт “Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, ... үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэсэн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсгийн “Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна.” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар 2015 оны 9 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.” гэсэн болно.

Тав. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 12 дугаар дүгнэлтийн тухай” 84 дүгээр тогтоолд:

“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт “Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна.” гэж заасны “...бусад төрийн албан хаагч...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэснийг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 12 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэжээ.



Зургаа. Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн харуу тайлбартаа:

“... Монгол Улсын Их Хурал 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 12 дугаар дүгнэлтийг хэлэлцэж, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэж, 2015 оны 84 дүгээр тогтоолыг гаргасан билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалт нь төрийн албаны тухайлсан албан тушаалтны хувьд сонгуульд өрсөлдөхөд хязгаарлалт тогтоож болно, зарим төрийн албан хаагчдад болохгүй гэсэн санааг агуулаагүй байна.

Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 12 дугаар дүгнэлтэд дурдсанчлан төрийн албан хаагчдыг “улс төрийн үйл ажиллагаанаас ангид байлгах, төвийг сахисан байр суурийг хадгалахад чиглэсэн тусгай шаардлага, шалгуурыг тавьж холбогдох хуулиар зохицуулах нь хууль тогтоогчийн бүрэн эрхийн асуудал” юм.

Монгол Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхийнхээ хүрээнд 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хэлэлцэн баталсан.

Уг хуулиар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсгийн “Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч” гэснийг “Төрийн жинхэнэ албан хаагч болон Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан” гэж өөрчилсөн бөгөөд энэхүү өөрчлөлт нь Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргагч иргэний шаардлага болон Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 12 дугаар дүгнэлтийн үндэслэл хэсгийн агуулгад нийцэж байгаа бөгөөд нөгөө талаар Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэсэн хуулийн заалт өөрчлөгдсөнөөр шинэ нөхцөл байдал үүсгэж байгаа болохыг уламжилж байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурал 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсгийн “Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч,” гэснийг “Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан,” гэж өөрчлөн баталсан байна.

Уг өөрчлөлт нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт хэт өргөн хүрээнд тавьсан шаардлагыг тодорхой болгосноороо уг зохицуулалтыг Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 12 дугаар дүгнэлтийн агуулгад нийцүүлсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

2. Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааны явцад өргөдөл гаргагч, иргэн Ч.Өлзийсайхан Улсын Их Хурал 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26



дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт оруулсан өөрчлөлт нь түүний өргөдлийн шаардлагыг бүрэн хангасан байна гэж хэлснийг дурдах нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг; Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг; Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын Их Хурал 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсгийн “Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч,” гэснийг “Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан,” гэж өөрчилж Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 12 дугаар дүгнэлтийн үндэслэлийн агуулгад нийцүүлсэн байгааг дурдсугай.

2. “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 12 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 84 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

Ж.АМАРСАНАА

ГИШҮҮД

**Н.ЖАНЦАН
Т.ЛХАГВАА
Ш.ЦОГТОО
Д.СУГАР
Д.НАРАНЧИМЭГ
Д.СОЛОНГО
Д.ГАНЗОРИГ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1

Индекс: 14003